



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.03.21 № 3/498
танай _____-ны № _____-т

“ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН
ХАДГАЛАМЖИЙН ТӨВ” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ш.ЛХАГВА
ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, 15 дугаар зүйлийн 15.1.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээний, өмчийн өөрчлөлтийн тайлан болон холбогдох тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид СТОУС гэх) түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санхүүгийн тайлангууд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид СТОУС гэх) түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Аудитаар тус компанийн өглөг дансад бүртгэлтэй нийт 10,288.0 сая төгрөгийн 282252 харилцагчийн ногдол ашиг, ногдол хувь эзэмшигчдийн мөнгийг тэдгээр харилцагчдын жагсаалтаас 88-г сонгон түүвэрлэснээс 56 харилцагч ирж тулган баталгаажуулахад тэдгээр харилцагчид өөрийн эзэмшлийн мөнгийг мэдэхгүй байсан ба бид дээрх өглөгүүд бодитоор оршин байгааг бүрэн нотолж чадаагүй болно.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Хязгаарлалттай дүгнэлт

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-ийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан, дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

